



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

“Гроут финанс аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд  
оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх  
хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.17, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гроут финанс аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Гроут финанс аудит” ХХК /Б.Бямба/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000072